



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/012/НА-СТА-ЗГТС

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: С.Гантөгс Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Цолмон Утас: 325093 Цахим хаяг: tsolmonba@audit.gov.mn</p> <p>Аудитор: М.Өлзийхишиг Утас: 325093 Цахим хаяг: ulziikhishigm@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	Error! Bookmark not defined.
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	Error! Bookmark not defined.
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	Error! Bookmark not defined.
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	Error! Bookmark not defined.
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	Error! Bookmark not defined.
Error! Bookmark not defined.	
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал.....	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ...	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
Error! Bookmark not defined.	
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.	Error! Bookmark not defined.
defined.	
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	Error! Bookmark not defined.
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	0

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХҮЕГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар
ГБХНХЯ	Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
СБД ЗДТГ	Сүхбаатар дүүргийн засаг даргын тамгын газар
НТАГ	Нийслэлийн төрийн аудитын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ
ДЭМЖИХ САНГИЙН ДАРГА О.БАТӨЛЗИЙ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар дүүргийн хөдөлмөр эрхлэлийг дэмжих сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант оны 1,895.6 сая төгрөгийн авлагын эцсийн үлдэгдэлтэй, үүнээс хугацаа хэтэрсэн 277.8 сая төгрөгийн авлагыг шүүхийн байгууллагад шилжүүлж барагдуулахаар арга хэмжээ авч ажилласан байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлд тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий удирдлагын шийдвэр, ажил гүйлгээ, үйл явдал үүсээгүй болно.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор 2025 онд 678.2 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй гэрээ байгуулж ажилласан байна.

Бусад асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,937,868,339.85</u>	<u>1,896,025,067.68</u>
33	АВЛАГА	1,937,868,339.85	1,896,025,067.68
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	465,000.00
335	Бусад авлага	1,937,868,339.85	1,895,560,067.68
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,908,618,339.85	1,895,560,067.68
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,937,868,339.85</u>	<u>1,896,025,067.68</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>383,002,100.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	465,000.00
413	Өглөг	-	465,000.00
4136	Бусад өглөг	-	465,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	465,000.00
417	Хөтөлбөртэй холбоотой өглөг		382,537,100.00
41710	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр		269,566,600.00
41711	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох ажлын байр хадгалах		1,890,000.00
41712	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих		69,666,000.00
41713	Засгийн газар, ХӨҮЗ, бусад шийдвэрээр тодорхойлсон хөтөлбөр төслийн санхүүжилт		19,800,000.00
41714	Хөдөлмөрийн салбарын ажилтнуудын сургалт		3,050,000.00
41715	Хөтөлбөр төслийн хяналт, үнэлгээ		110,000.00
41716	Ахмад мэргэжилтний зөвлөгөө өгөх үйлчилгээ		12,694,500.00

41717	Хүүхэд хамгаалагч төсөлтэй холбоотой өглөг		5,760,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,937,868,339.85	1,513,022,967.68
51	Засгийн газрын хувь оролцоо	1,937,868,339.85	1,513,022,967.68
512	Хуримтлагдсан үр дүн	1,937,868,339.85	1,513,022,967.68
51210	Өмнөх үеийн үр дүн	2,546,407,000.32	1,908,618,339.85
51220	Тайлант үеийн үр дүн	(608,538,660.47)	(395,595,372.17)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,937,868,339.85	1,896,025,067.68

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,341,320,019.31	1,883,346,589.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,331,320,019.31	3,541,224,989.25
120	Нийтлэг татварын бус орлого	2,331,320,019.31	3,541,224,989.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,327,564,200.00	3,303,647,800.04
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,159,932,000.00	1,875,171,420.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	619,007,200.00	744,750,480.04
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	548,625,000.00	683,725,900.00
120009	Бусад орлого	3,755,819.31	3,551,589.21
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	-	234,025,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,000,000.00	(1,657,878,400.00)
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	(1,657,878,400.00)
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	-	(1,657,878,400.00)
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,949,858,679.78	2,278,941,961.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,949,858,679.78	2,278,941,961.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,909,825.00	41,287,228.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,909,825.00	41,287,228.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,909,825.00	41,287,228.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,912,948,854.78	2,237,654,733.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	311,752,343.00	584,924,568.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	311,752,343.00	584,924,568.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	649,475,832.00	1,127,169,824.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	649,475,832.00	1,127,169,824.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,151,089,116.00	480,750,480.04
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,151,089,116.00	480,750,480.04
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	800,631,563.78	44,809,861.38
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	800,631,563.78	44,809,861.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(608,538,660.47)	(395,595,372.17)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(608,538,660.47)	(395,595,372.17)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,873,571,935.31	1,883,346,589.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,863,571,935.31	3,541,224,989.25
120	Нийтлэг татварын бус орлого	2,863,571,935.31	3,541,224,989.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,859,816,116.00	3,537,673,400.04
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,159,932,000.00	2,067,238,838.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	619,007,200.00	744,750,480.04
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	1,080,876,916.00	725,684,082.00
120009	Бусад орлого	3,755,819.31	3,551,589.21
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,000,000.00	(1,657,878,400.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10000000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10000000.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,670,277,679.78	2,574,604,861.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,670,277,679.78	2,574,604,861.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,909,825.00	38,127,228.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,909,825.00	38,127,228.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,909,825.00	38,127,228.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,633,367,854.78	2,536,477,633.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,032,171,343.00	883,747,468.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,032,171,343.00	883,747,468.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	649,475,832.00	1,273,813,755.25
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	649,475,832.00	1,273,813,755.25
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,151,089,116.00	337,658,138.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,151,089,116.00	337,658,138.00

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	800,631,563.78	41,258,272.17
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	800,631,563.78	41,258,272.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(796,705,744.47)	(691,258,272.17)
14	Бусад эх үүсвэр	796,875,744.47	691,258,272.17
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	796,875,744.47	691,258,272.17
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	796,875,744.47	691,258,272.17
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,937,868,339.85	0.00	1,937,868,339.85
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(29,250,000.00)		(29,250,000.00)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,908,618,339.85	0.00	1,908,618,339.85
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
C07	Тайлант үеийн үр дүн			(395,595,372.17)		(395,595,372.17)
C08	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,513,022,967.68	0.00	1,513,022,967.68

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,206,063,220.00	921,874,696.00	1,284,188,524.00	41.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,206,063,220.00	921,874,696.00	1,284,188,524.00	41.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	52,030,000.00	38,127,228.00	13,902,772.00	73.28
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,030,000.00	38,127,228.00	13,902,772.00	73.28
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,030,000.00	38,127,228.00	13,902,772.00	73.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,154,033,220.00	883,747,468.00	1,270,285,752.00	41.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,154,033,220.00	883,747,468.00	1,270,285,752.00	41.03
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,154,033,220.00	883,747,468.00	1,270,285,752.00	41.03

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2025 онд ахмадын санхүүгийн дэмжлэг олгосон иргэдээс 1 нэр бүхий иргэн 12 сард эргэн төлөлт хийгээгүй хугацаа хэтрүүлсэн байна.	1	416.0					1	416.0
Нас барсан иргэдийн авлагад эсрдлийн сан үүсгэх талаар холбогдох журам байхгүй, НБББББ-т тусгаагүй байна.	1	-					1	-
Дүн	2						2	416.0